



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1058  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Ардчилал шинэчлэлийн нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Ардчилал шинэчлэлийн нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилал шинэчлэлийн нам”-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichigi\2024\0420 GNAG-3.Docx

0001030701

# АРДЧИЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН НАМ




## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ШИНЭЧЛЭЛ 2024” МӨРИЙН ХӨТӨЛБӨР




Улаанбаатар хот 2024 он





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ АРДЧИЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН НАМ:**

- МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ, БҮРЭН ЭРХТ БАЙДЛЫГ БАТАТГАН БЭХЖҮҮЛЖ, ҮНДЭСНИЙ ТҮҮХ СОЁЛ, ХЭЛ БИЧИГ, ӨВ УЛАМЖЛАЛАА ХАДГАЛАН, ТӨРИЙН ЗАЛГАМЖ ЧАНАРЫГ ДЭЭДЭЛЖ,
- АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, ШУДАРГА ЁС, ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙГ ЭРХЭМЛЭН,
- ХУВЬ ХҮН, ӨРХ ГЭРИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ӨМЧИЙН БҮХ ХЭЛБЭРИЙГ ДЭМЖИЖ, БАЯЛАГ БҮТЭЭГЧ, ЧИНЭЭЛЭГ ДУНДАЖ ДАВХРАГЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, БАЙГАЛИЙН БАЯЛАГЫН ҮР ШИМИЙГ АРД ИРГЭДЭД ТЭГШ ХҮРТЭЭХ ХАРИУЦЛАГАТАЙ НИЙГМИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООНО.



**АРДЧИЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН НАМ**




**00000001**

## “ШИНЭЧЛЭЛ 2024” МӨРИЙН ХӨТӨЛБӨР


Шинэчлэл бол хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн нийгмийн бүхийл салбарт сайн өөрчлөлт төлөвшүүлэх үйл явц юм.

### Нэг: Эдийн засгийн хөгжлийн талаар

1. Улсын нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгаж, төсөв, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хуримтлалын сангуудыг иж бүрнээр нь бүрдүүлж, хөрөнгөжүүлэх, хянах бодлогыг баримтална.
2. Төсвийн төвлөрлийг бууруулж, орон нутагт төсвийн эрх мэдэл олгож, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
3. Мал аж ахуйн үйлдвэрлэлээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх үе шатандбанк, санхүүгийн байгууллага, үйлдвэр, малчны хамтын ажиллагаа, уялдааг сайжруулан, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, малчны орон нутагтаа ажиллаж, амьдрахнөхцлийг дээшлүүлэх бодлого баримталж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.*/Үндэсний Зөвлөлдөх хорооны 2024 оны 04 сарын 11-ний өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/*
4. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар экологийн эрүүл хүнс үйлдвэрлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.
5. Газар тариалан эрхлэлтийг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хүн амыг эрүүл аюулгүй, шим тэжээл сайтай дотоодын хүнсээр жигд, хүртээмжтэй хангах бодлого баримтална.*/Үндэсний Зөвлөлдөх хорооны 2024 оны 04 сарын 11-ний өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/*
6. Хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэн хүлэмжийн аж болон туслах аж ахуйг хөгжүүлж, борлуулалтын нэгдсэн сүлжээг байгуулна.
7. Боомтууд болон тээвэр ложистикийн салбарын бодлогыг шинэчлэнэ.
8. Агаарын тээврийн эрх зүйн орчныг сайжруулах замаар дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжиж, орон нутгийн нислэгийн сүлжээг өргөжүүлнэ.*/Үндэсний Зөвлөлдөх хорооны 2024 оны 04 сарын 11-ний өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/*




9. Эрчим хүчний эрэлт, хэрэглээ, үйлдвэрлэл, борлуулалт, үр ашгийн зохистой харьцааг хангасан бодлого боловсруулна.
10. Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулна.
11. Хүн амын төвлөрөлийг сааруулах, шинэ төвлөрөл бий болгох зорилгоор “Шинэ нийслэл” байгуулах ТЭЗҮ-г боловсруулна
12. Ипотекийн зээлийн зохистой бодлого нэвтрүүлнэ.
13. Монгол Улсын аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах, салбарын бүтцийг олон тулгуурт болгох, өндөр технологи, нано-технологи, инновацийн бодлогоор тэтгэх эрх зүйн орчинг бий болгоно.
14. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ангиллыг оновчтой тодорхойлж, баялаг бүтээгчдийн бодит хэрэгцээнд үндэслэн төрөөс зорилтот дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.
15. Байгаль, соёлын өвийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц стандарт бүхий эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэнэ.
16. Эдийн засаг дахь бүтээмжийн менежментийг шинэчилж ажил эрхлэгчдийн орлогыг 2 дахин нэмэгдүүлнэ.
17. Технологийн дэвшил болон инноваци шингэсэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого баримталж, хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний экспортын эрх зүйн орчныг сайжруулна. /Үндэсний Зөвлөлдөх хорооны 2024 оны 04 сарын 11-ний өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/
18. Эдийн засгийн гадаад тэнцвэртэй байдлыг хангаж, гадаад валютын орох урсгалыг тогтвортой сайжруулан, төлбөрийн нийт тэнцлийг алдагдалгүй байлгана.
19. Гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлнэ.



20. Банк санхүүгийн салбарын чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, хүүгийн бодлогод шинэчлэлт хийж хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ.
21. Байгалийн баялагын үр өгөөжийг нийтэд хүртээмжтэй байх хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ. /Үндэсний Зөвлөлдөх хорооны 2024 оны 04 сарын 11-ний өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/
22. Стратегийн орд газруудын ашиглалтын болон хяналтын тогтолцоог сайжруулна.

### Хоёр: Нийгмийн хөгжлийн талаар

23. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмж, ур чадварт суурилсан цалин хөлсний тогтолцоонд шилжинэ.
24. Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилнэ.
25. Тэтгэврийн шинэчлэлийг эрчимжүүлж, олон давхаргат сонголттой тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлнэ.
26. Эрүүл мэндийн үндэсний төвүүдийг бүсчилж, нэгдсэн эмнэлэгүүдийг эрх зүй, эдийн засаг, засаглал, менежментийн хувьд бие даалган, удирдлагыг мэргэшсэн, улс төрөөс хараат бус, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
27. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн цалинг үе шаттайгаар нэмэгдүүлж нийгэм, эдийн засгийн баталгааг эрс сайжруулна.
28. “Өвдсөн хойно нь биш өвдөхөөс нь өмнө” бодлогоор халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлогооны зардлыг даатгалаас санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
29. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, гэрийн сургалтын хэлбэрээр өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
30. Багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулан багш бэлтгэх тогтолцоог чанаржуулна.
31. Их дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ.





32. Мэргэжлийн боловсрол эзэмшсэн буюу МСҮТ-д суралцаж байгаа монгол оюутнуудыг өндөр хөгжилтэй улс орнуудад дадлагажуулж, мэдлэг ур чадварыг нь сайжруулана.
33. Гарааны компаниудыг дэлхийн зах зээлд гарахад нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бий болгоно.
34. Соёл шинжлэх ухааны салбарын ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ.

**Гурав: Байгаль орчны хөгжлийн талаар**

35. Ногоон хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн тулгуур бодлого болгоно.
36. Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.

**Дөрөв: Төрийн албаны талаар**

37. Төрийн албанд шинэчлэлт хийж, мэдлэг боловсролтой боловсон хүчнийг сонгон авах, тогтвортой ажиллуулах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.
38. Мэргэшсэн, чадварлаг хууль сахиулах байгууллагатай байхын тулд цагдаагийн албаны сургалтын шинэ тогтолцоог бүрдүүлнэ.
39. Хуулийн байгууллагын ажилтнуудад хариуцлага тооцох механизмыг бий болгоно.
40. Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлнэ.
41. Авлигыг үндсээр нь таслах хууль эрх зүйн орчныг бий болгоно.
42. Төрийн бараа үйлчилгээ худалдан авах Тендер шалгаруулах аргад шинэчлэлт хийж ил тод болгоно

-о О о-



00000075